

Олон нийтэд сургалт, тэмцээн уралдаан зохион байгуулсан тайлан

2023.12.06

• "Энэ жилдээ-Эрүүл жиндээ" аяны хүрээнд "Бүжгээр эрүүлжье" уралдааныг Байгалийн ухааны ЗАН-ээс зохион байгууллаа. Уралдаан төсвийн болон аж ахуйн нэгж албан байгууллагуудын дунд /багийн мэндчилгээ, Золбоот шугаман бүжиг-аэробик хөдөлгөөнт дасгал, хосын үзүүлбэр-/цэнгээнт бүжиг/ 3 төрлөөр явагдлаа. Уралдааны багийн дүнгээр:

- 1-р байранд Collection баг хамт олон / МОНХАРБОР сувилал, Хаан банк, Соёлын төв, Төрийн банк, Колонкууд, цаг уур, Гялс төгрөг/
- 2-р байранд Хүүхдийн цэцэрлэгийн баг хамт олон
- 3-р байранд Ахмадын хорооны баг хамт олон тус тус шалгарлаа. Мөн аяны хүрээнд сургуулийн багш, ажилтан тогтмол мягмар гаригийн 17 цагаас "Хөгжимт гимнастик" хийн, өөрийн сонирхдог спортын төрлөөрөө хичээллэж, чөлөөт цагаараа бие бялдрыг чийрэгжүүлэх дасгал хөдөлгөөн хийн хэвшиж байна.



- Сургуулийн нээлттэй хаалганы өдөрлөгийг эцэг эх, асран хамгаалагчдын төлөөллийн дунд үеэр өртөөчилсэн хэлбэрээр 05 сарын 05 өдөр зохион байгууллаа. Өдөрлөгөөр хөрөнгө оруулалт, багш, сурагчдынхаа амжилт, бүтээл, сурлагын ахиц, БАГҮ болон анги дэвших, төгсөх шалгалт, эцэг эхийн харилцаа, вертуал, СТЕМ болон Иргэний боловсролын кабинетууд, хими, физикийн хичээл сургалтын хэрэглэхүүн туршилтууд, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, үдийн болон дотуур байрны хоолны чанар, орцын амталгааг тус тус танилцуулан асран хамгаалагч

нартай нээлттэй ярилцлага хийлээ. Мөн “Тойрон бүжиг” бүжиглэж, хөгжөөнт тэмцээнүүдийг зохион явуулсан.



- Насан туршийн суралцахуйд бүртгэлтэй суралцагчдад үндэсний хөтөлбөр III-ийн хүрээнд цахим хичээл, зөвлөмж мэдээллийг цахим хуудсанд бэлтгэн байршуулсан. Мөн сумын насанд хүрэгчдийн дунд үндэсний бичгийн “Түргэн уншлага”, “Цэвэр бичвэр”-ийн уралдааныг насан туршийн суралцахуйн төв, монгол хэлний ЗАНэгдэлт хамтран зохион байгуулсан. Уралдаанд 15 иргэн хамрагдсан.



- "Өөрт байгаа илүү шинэ зүйлсээ хандивлая" 1 өдрийн аянг Ц.Ууганям багштай 3а анги, Б.Одонтуяа багштай 3б ангийн хамт олон зохион байгуулан аянд 740,000 төгрөгний үнэ бүхий эд зүйлсийг цугларан дотуур байранд амьдардаг дунд ангийн бүтэн өнчин 2 хүүхдэд сэтгэлийн хандив өгөв.



- Тамхины хяналтын тухай хуулийг сурталчлах, нийтийн биеийн тамир, эрүүл мэндийг дэмжих, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Тамхичин биш Тамирчин” волейболын шилжин явах цомын нэрэмжит тэмцээн 2023 оны 04 сарын 29-ны өдөр албан байгууллага, ААН-үүдийн дунд зохион явуулагдлаа. Тэмцээнийг сургуулийн захиргаа, сумын залуучуудын холбоо хамтран зохион байгуулсан. Багийн дүнгээр ЗДТГ шилжин явах цом тэргүүн байр эзэллээ.



- Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой шинээр батлагдан хэрэгжиж буй бага, дунд боловсролын тухай хуулийн сургалтыг зохион байгуулан мэдлэгийг бататгаж ЗАН-ийн дунд КАХООТ программаар танин мэдэхүй хуулийн тэмцээнийг 11 сарын 23-нд зохион байгуулсан. Тэмцээнд нийт 6 баг оролцсон.

Тэргүүн байранд Монгол хэлний ЗАН

Дэд байранд Гадаад хэлний ЗАН

Гутгаар байранд Байгалийн ухааны заах аргын нэгдэл тус тус шалгарсан.



- “Үндэсний бичиг үсгийн баяр” олимпиад, уралдаан аймгийн хэмжээнд 13 чиглэлээр зохион байгуулагдлаа. “Төрийн албан хаагчдын их сорилго”-д 8 сумын нийт 150 албан хаагч, “Төрийн албан хаагчдын цахим бичвэр” уралдаанд 28 байгууллагын 58 төрийн албан хаагчид оролцсоноос Эрдэнэдалай сумаас 8 төрийн албан хаагч оролцлоо.
- “Монгол хэл, бичгийн хичээлийн 10-р ангийн анги нийтийн олимпиад”-д: Л.Гэрэлмаа багштай 10в анги / Тэргүүн байр /

- 9-р ангийн анги нийтийн олимпиад"-д: М.Дэлгэрмаа багштай 9а анги /Тэргүүн байр/
- “Төрийн албан хаагчдын цахим бичвэр” уралдаанд Цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын ангилалд”:Бага ангийн багш Т.Мөнхзаяа /5р байр / Биологийн багш Б. Эрдэнэсүрэн /6р байр /
- “Төрийн албан хаагчдын их сорилго”-д: Бага ангийн багш Ц.Гантуяа /Тусгай байр/, Бага ангийн багш Б.Туул / Тусгай байр/
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах ажилтны ангилалд”:Сургалтын менежер П.Өнөрцэцэг /Гутгаар байр/ тус тус шалгарсан.



- Технологийн багш Г.Энхтуяа нь цаасан урлал мөн давсан урлал 60 гаруй төрлийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж сумын иргэд хүүхэд багачуудад танилцууллаа.



- Насан туршийн суралцахуйн нэгжээс амьдрах ухааны боловсролын чиглэлээр:
 - Байгалийн гамшигт үзэгдлүүд болох ган, зуд
 - Агаар мандал дах тунадасны нэршлийн тухай

Гэр бүлийн боловсрол:


- Насан туршийн боловсрол гэж юу вэ?
- Нийгэм ба сэтгэлзүйн хэрэгцээ
- Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил

Санхүүгийн боловсрол:

- Хадгаламжийн үнэ цэнэ

Иргэний боловсрол:

- Ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй сэдвүүдээр мэдээлэл бэлтгэн иргэдэд НТБ-ын цахим хуудас, Эрдэнэдалай сумын АСА FM радио болон брошур хэлбэрээр танилцуулан ажиллаа.



- “Эрх зүйн хөтөч” ЗДТГ-аас Эрдэнэдалай сумын хэлний бодлогын салбар зөвлөлийн багийн ажлын хүрээнд НТБНэгжээс иргэдийн дунд монгол бичгийн түвшин тогтоох судалгааг түүврийн аргаар авлаа. 04 сарын 20-ны байдлаар судалгаанд 15-50 насны нийт 26 иргэн хамрагдсан байна. Судалгааг дүгнэвэл: Уйгаржин бичгийн үсэг мэддэг эсэх 50% дунд, 26.9% сайн, 15.4% бага, 7.7% огт мэдэхгүй. Бичиж чаддаг эсэх 46.2% дунд, 26.9% бага, 11.5% сайн, 11.5% огт мэдэхгүй. Уншиж чаддаг эсэх 34.6% дунд, 26.9% бага, 23.1% сайн, 15.4% огт чадахгүй гэж хариулжээ.
- “Насан туршийн суралцахуйн үйл ажиллагаа”-ны талаар сургалт мэдээллийг зохион байгуулсан. Сургалтыг нийт 166 иргэд, малчдад зохион байгуулсан.

